| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                | 50,000,000.00         | 50,000,000.00         | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /



Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| ДАНС   | ҮЗҮҮЛЭЛТ                                                                    | ТӨЛӨВЛӨГӨӨ            | ГҮЙЦЭТГЭЛ             | Хувь |
|--------|-----------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|------|
|        | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                     | -                     | <b>0.00</b>           | -    |
| 2      | <b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                                 | <b>64,454,950.46</b>  | <b>64,454,950.46</b>  | 100  |
| 21     | <b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>                                                   | <b>64,454,950.46</b>  | <b>64,454,950.46</b>  | 100  |
| 210    | Бараа, үйлчилгээний зардал                                                  | 64,454,950.46         | 64,454,950.46         | 100  |
| 2101   | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                                           | 7,281,929.25          | 7,281,929.25          | 100  |
| 210102 | Нэмэгдэл                                                                    | 7,281,929.25          | 7,281,929.25          | 100  |
| 2102   | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                       | <b>910,241.21</b>     | <b>910,241.21</b>     | 100  |
| 210201 | Тэтгэврийн даатгал                                                          | 618,964.00            | 618,964.00            | 100  |
| 210202 | Тэтгэмжийн даатгал                                                          | 72,819.30             | 72,819.30             | 100  |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал                                                           | 58,255.48             | 58,255.48             | 100  |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал                                                        | 14,563.85             | 14,563.85             | 100  |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал                                                       | 145,638.58            | 145,638.58            | 100  |
| 2104   | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                     | <b>4,858,500.00</b>   | <b>4,858,500.00</b>   | 100  |
| 210401 | Бичиг хэрэг                                                                 | 1,573,500.00          | 1,573,500.00          | 100  |
| 210402 | Тээвэр (шатахуун)                                                           | 2,415,000.00          | 2,415,000.00          | 100  |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс                              | 870,000.00            | 870,000.00            | 100  |
| 2106   | <b>Эд хогшил худалдан авах</b>                                              | <b>22,143,800.00</b>  | <b>22,143,800.00</b>  | 100  |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл                                                     | 13,362,100.00         | 13,362,100.00         | 100  |
| 210602 | Тавилга                                                                     | 6,581,900.00          | 6,581,900.00          | 100  |
| 210604 | Урсгал засвар                                                               | 2,199,800.00          | 2,199,800.00          | 100  |
| 2107   | <b>Томилолт, зочны зардал</b>                                               | <b>3,951,800.00</b>   | <b>3,951,800.00</b>   | 100  |
| 210702 | Дотоод албан томилолт                                                       | 3,951,800.00          | 3,951,800.00          | 100  |
| 2108   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>                      | <b>25,308,680.00</b>  | <b>25,308,680.00</b>  | 100  |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж                    | 24,246,680.00         | 24,246,680.00         | 100  |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал                              | 1,062,000.00          | 1,062,000.00          | 100  |
|        | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                       | <b>112,250,379.06</b> | <b>112,250,379.06</b> | 100  |
| 1320   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | <b>8,192,170.46</b>   | <b>8,192,170.46</b>   | 100  |
| 132001 | Орон нутгийн төсвөөс                                                        | 8,192,170.46          | 8,192,170.46          | 100  |
| 1311   | Нэмэлт санхүүжилтийн орлого                                                 | 104,058,208.60        | 104,058,208.60        | 100  |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 104,058,208.60        | 104,058,208.60        | 100  |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь Монгол Улсын хун амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хүн амын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлсэн бүс нутаг, хот, суурин газрыг төлөвлөх, байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилго, үндсэн чиг үүрэг бүхий Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын харьяа байгууллага юм.

2023 оны нийт төлөвлөгдсөн зардлын санхүүжилтийн эх үүсвэр төлөвлөгөө 545,431.6 мянган төгрөг, гүйцэтгэл 448,023.3 мянган төгрөг буюу гүйцэтгэл 82.1 хувьтай байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон дараах бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Газрын тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоол ;
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол “Автомашин ашиглалтын тухай”;
- Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”;Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.



Тус байгууллага дотоод хяналтын чиг үүргийг газрын даргын тушаалаар батлагдсан журам зааврыг мөрдлөг болгодог. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг засаж, зөвлөмжийг биелүүлэн ажилласан тул байгууллагын дотоод хяналтын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар түүнийг аудитад ашиглахгүй гэж үзлээ.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны хувьд Хөдөлмөрийн тухай хууль, Барилгын тухай хууль, Газрын тухай болон бусад хуулиудад нийцүүлэн гарсан дээд шатны байгууллагуудын тогтоол, журам, тушаал, шийдвэрүүдийг өөрийн үйл ажиллагаандаа даргын тушаалаар тухай бүрт нь өөрчлөлт оруулан мөрдлөг болгон ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг аудитын зарим горим, сорилыг гүйцэтгэхэд картаар эзэмшиж буй зарим хөрөнгийн кодлолт, болон хадгалалт, хамгаалалтад анхаарах асуудлууд байсан нь түүнд тавих хяналт алдагдах, хөрөнгөд эрсдэл гарч болзошгүй гэж үзэв.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага аймгийн хэмжээнд мөрдөж байгаа нийтлэг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 116,828.8 төгрөгөөр буюу 43.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний<br>үлдэгдэл | /мянган төгрөгөөр/ |          |
|----------|-------------------|--------------------|----------|
|          |                   | Эцсийн<br>үлдэгдэл | Өөрчлөлт |

| Б                                            | 1                | 2                | 3=2-1            |
|----------------------------------------------|------------------|------------------|------------------|
| Мөнгөн хөрөнгө                               | 3,523.5          | 6,956.7          | 3,433.2          |
| Авлага                                       | 0.0              | 4,614.1          | 4,614.1          |
| Бараа материал                               | 65,642.4         | 62,009.7         | -3,632.7         |
| Үндсэн хөрөнгө                               | 198,590.4        | 311,004.6        | 112,414.2        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>267,756.3</b> | <b>384,585.1</b> | <b>116,828.8</b> |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 267,756.3        | 384,585.1        | 116,828.8        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>267,756.3</b> | <b>384,585.1</b> | <b>116,828.8</b> |

Дээрх хүснэгтээс харахад, дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 3,433.2 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн сангаас ахмадын санд төвлөрүүлсэнтэй холбоотой;
- Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 4,614.1 мянган төгрөгөөр өссөн нь ГЗБГЗЗЕГ-ын даргын 1/180 тоотын дагуу Барилгын хөгжлийн төвөөс авах барилга, техник хяналтын орлоготой холбоотой;
- Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 3,632.7 мянган төгрөгөөр буурахад газрын даргын тушаалаар 1,746.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан нь нөлөөлсөн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 116,828.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд элэгдлийн зардлаар өртгөө нөхсөн цаашид ашиглах үндсэн хөрөнгийг ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоож бүртгэсэнтэй холбоотой;

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 453,531.6 мянган, үйл ажиллагааны орлогоос 50,000.0 мянган, нийт зарлагыг 503,531.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 98,400.0 мянган төгрөгөөр бууруулж, 405,131.6 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна. Энэ нь төсвийн хэмнэлтийн хуульд нийцүүлсэнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 140,300.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 545,431.6 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71504 хөтөлбөрийн 80101 арга хэмжээг санхүүжүүлэхээр 495,431.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 50,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр баталжээ.



Гүйцэтгэлээр улсын төсвөөс 495,431.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоос 50,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 448,023.3 мянган төгрөг буюу 82.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 97,408.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилт олгоогүй.

### **3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант онд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд батлагдсан төсвийн хүрээнд 28,450.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч орлогоор бүртгэсэн.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр, чанарын менежер Г.Цогтбаатар нар гүйцэтгэж, хяналтыг захирал М.Буянбулган болон Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 421,868.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 6,328.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Учир нь 2023 онд зарим эрх зүйн актуудад өөрчлөлт орсонтой холбоотой. Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 679,307.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож, материаллаг байдлыг 10,189.6.0 мянган төгрөгөөр тогтоов.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай 32 заалтын хэрэгжилтэд аудитын горим, сорил гүйцэтгэхээр төлөвлөж, хяналтыг хэрэгжүүлэв. Байгууллага төсвийн



үргүй зардал гаргахгүй байх, батлагдсан төсвийг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Хуулийн хүрээнд төсвийн хэмнэлтийг авч үзэхэд нийт урсгал зардал 97,408.3 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна. Үүнд: Цалин хөлс, болон нэмэгдэл урамшуулал 82,467.2 мянган болон ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл 9,157.6 мянган, байр ашиглалтын зардал 5,668.6 мянган, хангамж, бараа материалын зардал 11.4 мянган, томилолт, зочны зардал 97.8 мянган бусад зардлыг 5.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь нөлөөлжээ.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих нийт 171 мэдээллийг оруулахаас 170 мэдээллийг хугацаанд нь, хугацаа хоцроосон, байршуулаагүй тус бүр 1 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох" журмын 3 дугаар зүйлийн 3.2.10-тай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлж ажиллах албан шаардлага өгөв.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Үндэсний аудитын газраас зарласан сонгон шалгаруулалтаар Говьсүмбэр аймгийн багц 1-д тэнцэж, гурвалсан гэрээг 2023 оны 10 дугаар сарын 13-нд байгуулж, аудитын нээлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газартай шалгагдагч байгууллагуудын удирдлага, нягтлан бодогчдыг оролцуулан хийв. Завсрын аудитыг эхний 9 сарын санхүүгийн болон холбогдох баримт, байгууллагын үйл ажиллагаатай биечлэн танилцах ажилбаруудыг гүйцэтгэж, илэрсэн алдаа, зөрчлийн асуудлыг байгууллагын удирдлагад танилцуулж, уулзалтын тэмдэглэлээр баримтжуулсан.

Асуудлын бүртгэлийг жилийн дүнгээр нэгтгэн танилцуулж шийдвэрлүүлэхээр тогтсон болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон албан шаардлагын хэрэгжилтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 01/155 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                | Биелэлт  |                |              |
|-----------------|------------------------|----------------|----------|----------------|--------------|
|                 | Тоо                    | Дүн            | Тоо      | Дүн            | Хувь         |
| Акт             | -                      | -              | -        | -              | -            |
| Албан шаардлага | 1                      | 1,500.0        | 1        | 1,500.0        | 100.0        |
| Зөвлөмж         | -                      | -              | -        | -              | -            |
| <b>Нийт дүн</b> | <b>1</b>               | <b>1,500.0</b> | <b>1</b> | <b>1,500.0</b> | <b>100.0</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэлээр тавих дотоод хяналтын асуудлыг хэрхэн хэрэгжүүлж буйд анхаарах



## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 861.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрсэн зөрчилд төлбөрийн акт тогтоож, алдааг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмж тус бүр 1-ийг өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

#### 5.1.1 Цалингийн зардалтай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Нягтлан бодогчийн ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр олгосон боловч Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн А/89 дугаар тушаалаар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Зөрчилгүй" дүгнүүлсэн гэх үндэслэлээр урамшууллыг давхардуулан цалингийн сангаас олгосон.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 40.3 дэх "Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ", Төрийн албаны тухай хуулийн 51.1.4 дэх "Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.", заалтуудыг зөрчиж, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх

### 5.2 Албан шаардлага

#### 5.2.1 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд оруулах 171 мэдээллээс 170-ийг оруулснаас хугацаа хоцорсон 1, батлагдсан төсвийн хөрөнгийн хүрээнд худалдан авах төлөвлөгөөг боловсруулж байршуулаагүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "Мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх";

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" заалтуудыг зөрчиж, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны нэгдсэн системд оруулах мэдээллүүдийг тогтоосон хугацаанд журамд тодорхойлсон хавсралт дахь маягт мэдээллийн дагуу бүрэн, байршуулж байх

### 5.3 Зөвлөмж

#### 1. Дотоод хяналттай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Газрын даргын тушаалаар дотоод хяналтын ажилтан томилж, жилийн төлөвлөгөө гарган ажиллаж байгаа боловч шалгалтын тоо цөөн, санхүү, өмч эзэмшигчдэд тавих хяналт сул байдал ажиглагдсан. Тухайлбал: Түүвэр сонголтоор эзэмшигчийн картыг хариуцаж буй хөрөнгөтэй тулгахад кодлолт бүрэн бус, зарим барааны хадгалалт, хамгаалалтад анхаарах асуудлууд илэрсэн.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дугаар тогтоолын 4.1.5-т "Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт" заалтуудыг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын ажилтаны ажлыг оновчтой тодорхойлж, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга              | Нийт зөрчил |              | Үүнээс        |              |                 |          |          |          |                                      |                     |                                                 |          |
|---------------------------------|-------------|--------------|---------------|--------------|-----------------|----------|----------|----------|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|----------|
|                                 |             |              | Төлбөрийн акт |              | Албан шаардлага |          | Зөвлөмж  |          | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |          |
|                                 | Тоо         | Дүн          | Тоо           | Дүн          | Тоо             | Дүн      | Тоо      | Дүн      | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн      |
| Урамшуулал давхардуулан олгосон | 1           | 861.5        | 1             | 861.5        | -               | -        | -        | -        | -                                    | -                   | -                                               | -        |
| <b>Дүн</b>                      | <b>1</b>    | <b>861.5</b> | <b>1</b>      | <b>861.5</b> | <b>-</b>        | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b>                             | <b>-</b>            | <b>-</b>                                        | <b>-</b> |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга      | Нийт зөрчил |            | Үүнээс        |          |                 |            |          |            |
|-------------------------|-------------|------------|---------------|----------|-----------------|------------|----------|------------|
|                         |             |            | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |            | Зөвлөмж  |            |
|                         | Тоо         | Дүн        | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн        | Тоо      | Дүн        |
| Шилэн данстай холбоотой | 1           | 0.0        | -             | -        | 1               | 0.0        | -        | -          |
| Дотоод хяналт           | 1           | 0.0        | -             | -        | -               | -          | 1        | 0.0        |
| <b>Дүн</b>              | <b>2</b>    | <b>0.0</b> | <b>-</b>      | <b>-</b> | <b>1</b>        | <b>0.0</b> | <b>1</b> | <b>0.0</b> |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар

35/1120137

Чойр

ГА-2024/50/НА-СТА-ПМС

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Тус газрын нягтлан бодогчийн ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр олгосон боловч Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2023 оны 5 дугаар сарын 25-ний өдрийн А/89 дүгээр тушаалаар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Зөрчилгүй" дүгнүүлсэн гэх үндэслэлээр урамшууллыг давхардуулан цалингийн сангаас 861,490.00 (Найман зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун ерэн) төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 40.3 дэх "Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ", Төрийн албаны тухай хуулийн 51.1.4 дэх "Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.", Сангийн сайдын 2022 оны 28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 25 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно," Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

0008050177



1. Урамшууллыг давхардуулан олгосон 861,490.00 (Найман зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун ерэн) төгрөгийг удирдлага, санхүүгийн ажилтан нар хариуцан барагдуулж, Говьсүмбэр аймгийн Төрийн сан дахь **орон нутгийн орлогын “Төсөвт байгууллагын өөрийн орлого” 100220000954** тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Б.Отгончимэг, нягтлан бодогч Л.Туяа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

“БАТАЛГААТ ТООЦООЛОЛ АУДИТ” ХХК-ИЙН  
ЧАНАРЫН МЕНЕЖЕР

Б.САРАНТУЯА

Г.ЦОГТБААТАР



<sup>1</sup> Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, Нутгийн удирдлагын ордон, Утас:70543179



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 15/НМБ 0137  
ГА-2024/50/НА-ОТА-ТШЗ

Чойр

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд батлагдсан төсвийн хөрөнгийн хүрээн дэх худалдан авах төлөвлөгөөг бүрэн боловсруулж байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "Мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх," гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Б.Отгончимэг, нягтлан бодогч Л.Туяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.САРАНТУЯА

"БАТАЛГААТ ТООЦООЛОЛ АУДИТ" ХХК-ИЙН  
ЧАНАРЫН МЕНЕЖЕР

Г.ЦОГТБААТАР

<sup>1</sup> Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179

008040368



Байгууллагын нэр: Говьсүмбэр аймгийн [ХБХБГ]  
Тайлант хугацаа: 2023.01.01-2023.12.31

Байгууллагын РД: 9019073

Аудитын код: ГСА-2024/НА-СТА-ТШЗ  
Аудитын нэр: Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл  
Тайлант хугацаа: 2023 он

| №                                   | Ажил гүйцэтгэний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товчлол                                                                                                                                                                                                                                                                                                                                                   | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл       | Шалгагч байгууллагын холбогдох хүний |                     |
|-------------------------------------|---------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|---------------------------------------|-------------------------------------|--------------------------------------------|-----------------------|--------------------------------------|---------------------|
|                                     |                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |            |                                       |                                     |                                            |                       | Албан тушаал                         | Овог нэр            |
| А                                   | 1                                                 | 3                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | 4          | 5                                     | 6                                   | 7                                          | 8                     | 9                                    | 10                  |
| 1. Зөрчил                           |                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |            |                                       |                                     |                                            |                       |                                      |                     |
| 1                                   | Цалингийн зардал                                  | Нягтлан бодогчийн ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалыг тухай бичиг олгосон боловч Газар зохихон байгуулалт, геодэвч зураг зүйн газрын даргын 20/3 оны 5 дугаар сарын 25-ний өдрийн А/89 дугаар т/шаалаар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Зөрчлөх" дүгнүүлсэн гэх үндэслэлээр урамшуулалыг давхард уулан цалингийн сангаас олгосон байна. | 861,490.00 | Төлбөрийн акт тогтоох                 | Зөвшөөрсөн                          |                                            | Төлбөрийн акт тогтоох | Дарга нягтлан бодогч                 | Б.Отгончимэг Л.Туяа |
| 2. Нийтийн аудитын асуудлын бүртгэл |                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |            |                                       |                                     |                                            |                       |                                      |                     |
| 1                                   | Шилэн дансны хууль                                | Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд оруулах 171 мэдээлэлээс 170-ийг оруулснаас хугацаа хичирсон 1, батлагдсан төсвийн хөрөнгийн хүрээнд худалдан авах төлөвлөгөөг болгоо оруулж байршуулаагүй.                                                                                                                                                                       | 0.0        | Албан шаардлага өгөх                  | Зөвшөөрсөн                          |                                            | Дарга нягтлан бодогч  | Б.Отгончимэг Л.Туяа                  |                     |
| 2                                   | Дотоод хяналт                                     | Газрын даргын "ушаал" дотгоод хяналтын ажил тлан томилж, жилийн төлөвлөгөө гарган ажиллаж байгаа боловч шалгалтын тоо цөөн, санхүү, өмч зээмшигчдэд тавих хяналт сул байдал ажиглагдсан. Тухайлбал: Түүхэр сонголттой зээмшигчийн картныг харуулаж буй хөрөнгөтэй тулгахад кодоолт бүрэн бус, зарим барууны хад алагд, хамгаалалтад ачаарууд асуудлууд илэрсэн.           | 0.0        | Зөвлөмж өгөх                          | Зөвшөөрсөн                          |                                            | Дарга нягтлан бодогч  | Б.Отгончимэг Л.Туяа                  |                     |
| Дүн                                 |                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | 861,490.00 |                                       |                                     |                                            |                       |                                      |                     |

Бэлтгэсэн: Батлагдсан тухайлбал аудит ХХБ-ийн  
Захирал М.Бухаагийнх  
Хянасан: Аудитын менежер Г.Наранбал Огноо:  
Хянасан: Дарга, Тэрүүлэх аудитор Б.Сарантуяа Огноо:

Танилцаж зөвшөөрсөн:  
Дарга  
Нягтлан бодогч

Б.Отгончимэг Огноо:  
Л.Туяа Огноо: